



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 26 өдөр

Дугаар АБ 75

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 17 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Говь-Алтай 80+" хөтөлбөрийн хүрээнд эрт илрүүлэг үзлэг оношилгоо, явуулын эмнэлгийн үйлчилгээг Бугат, Тонхил, Төгрөг сумдын малчдад оршин суугаа газар нутагт нь хүргэх, тэдний өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор Бугат сумын "Дөрөлжийн нуур"-т багуудын нэгдсэн өдөрлөг зохион байгуулах ажлын хүрээнд малчдад төрийн үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Зардалд шаардагдах 15.530.000 (арван таван сая таван зуун гучин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс, (Д.Буянхишиг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ



_____ (_____) : _____ : _____ (_____) _____

_____ .. _____ _____ _____ _____ _____

_____ (_____) _____ _____ _____ _____

_____ .. _____ _____ _____ _____

_____ _____ _____ _____ _____

_____ _____ _____ _____ _____

_____ .. _____ _____ _____ _____

_____ _____ _____ _____ _____



Аймгийн Засаг даргын 2025 оны
 06 дугаар сарын 28 -ны өдрийн 15 дугаар
 захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Ажлын хэсгийн суудлын автомашины шатахуун	537 л	3200	1,718,400
2	Явуулын амбулаторийн 2 машины шатахуун	2831л	3390	9.597.090
3	Том дэлгэц угсрах, хүргэх үйлчилгээний хөлс	-	2,400,000	2,400,000
4	Шагнал урамшуулал	-	1,810,000	1,814510
5	Нийт мөнгөн дүн			15,530,000

__ оОо __